



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/750

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сумдын Засаг даргын Тамгын газрын Эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, архив бичиг, хэргийн ажилтнуудыг арга зүйн удирдлагаар хангах, чадавхжуулах цахим сургалтын зардалд 340.000 төгрөгийг хавсралтын дагуу зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 340.000 төгрөг /Гурван зуун дөчин мянган/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт хөтөлбөр арга хэмжээний 4.12 дахь заалтын "Иргэдийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 03-ны өдрийн
А/750 захирамжийн хавсралт



СУМДЫН ЭРХ ЗҮЙ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
АРХИВ БИЧИГ, ХЭРГИЙН АЖИЛТНУУДЫГ ЧАДАВХИЖУУЛАХ
СУРГАЛТЫН ТӨСӨВ

д/д	Төрөл	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /мянган төгрөгөөр
1	Гарын авлага, номлосон материал хийлгэх	34	10.000	340.0
Нийт дүн				340.0

-oOo-